



МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО

“Илүү сайхан ирээдүйн төлөө” Олон улсын чуулга уулзалт

“ИЛҮҮ САЙХАН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ” ТУНХАГЛАЛ

Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо (МЭХ) нь 95 жилийн түүхтэй, ази тивд байгуулагдсан эмэгтэйчүүдийн анхны байгууллагын хувьд охид эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, жендэрийн тэгш байдлыг хангахаар зорьж, “Илүү сайхан ирээдүйн төлөө” Олон улсын чуулга-уулзалтыг 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хотноо Монгол Улсын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулж, бусад улс орны туршлагатай танилцаж, өөрийн орны онцлогт нийцүүлэн сайжруулах бодлого, үйл ажиллагааны тодорхой саналуудыг 10 гаруй улс орнуудын зочид, 21 аймаг, 330 сум, 9 дүүргийн нийт мянга гаруй төлөөлөгчийн оролцоотой хэлэлцлээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70/1 тоот тогтоолоор 2015 онд баталсан Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх зорилтын 5 дугаарт тусгаснаар, охид, эмэгтэйчүүд улс төр, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт болон удирдах, шийдвэр гаргах түвшинд хөвгүүд, эрэгтэйчүүдтэй эрх тэгш боломжоор хангагдсан байх ёстойг тогтоосон. Охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хөвгүүд эрэгтэйчүүдийн оролцоотойгоор устгана¹ гэж уриалсныг НҮБ-ын гишүүн орны хувьд Монгол улс хүлээн авсан учир Монгол улсын Засгийн газар хүчин чармайлт гаргаж, 2018 онд “Тогтвортой хөгжлийн бодлого-жендэр ба хөгжил” сэдвийн дор чуулж “Улаанбаатар тунхаглал” гаргасан. Энэхүү тунхаглалаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, охид эмэгтэйчүүдийн тэгш бус байдлыг бууруулахад илүү анхаарал хандуулж байна.

Монгол улсын хувьд жендэрт суурилсан хүчирхийлэл тэр дундаа бага насны охид бэлгийн хүчирхийлэлд өртөх явдал нэмэгдэж, эдийн засгийн идэвхигүй эмэгтэйчүүдийн тоо жилээс жилд өсч, улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх тэдний оролцоо олон улсын дундаж үзүүлэлтээс доогуур байгаа зэрэг асуудлууд тулгамдаад байна.

ИЙМД ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОГЧИД БИД,

- охид, эмэгтэйчүүд нь улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралын оролцооны хувьд хөвгүүд, эрэгтэйчүүдтэй тэгш боломжоор хангагдах нь шударга, эрх тэгш, нээлттэй, нийгмийн хөгжлийн үйл явцад хэнийг ч орхигдуулахгүй байх гол арга зам мөн гэдгийг хүлээн зөвшөөрч,
- эмэгтэй эрэгтэй хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг судлан, бодлого төлөвлөлтөд тусгах, төсөв хөрөнгийг зохистой хуваарилах замаар үр ашгийг тэгш хүртээх амлалтаа санаж,
- охид, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс ангид байлгаж, “Илүү сайхан ирээдүйн төлөө” санаачлагуудыг хэрэгжүүлэх улс төрийн намуудыг дэмжин хамтран ажиллах үүргийг хүлээж байна. Үүнд:

НЭГ. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх нэгдсэн бодлого, хөтөлбөр гаргах хүрээнд:

- Улс орныг хөгжүүлэх урт хугацааны бодлого болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогод жендэрийн дүн шинжилгээ хийж, олон улсын өмнө хүлээсэн амлалтын дагуу НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтод нийцүүлэн сайжруулах
- Орон нутаг болон улсын төсөв төлөвлөлт, гүйцэтгэлийг жендэрийн мэдрэмжтэй болгох аргачлалыг нутагшуулах
- эмэгтэйчүүдийн онцлогт нийцсэн банк санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлэх, тэдний бүтээгдэхүүний борлуулалтын тусгай арга хэмжээ авах

¹ НҮБ-ын ТХЗ 2030, 20

- Эмэгтэйчүүд нь үр хүүхдээ төрүүлж өсгөхийн зэрэгцээ сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх боломжийг олгосон тусгай арга хэмжээний хөтөлбөр гарган хэрэгжүүлэх
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг олон улсын гэрээ, конвенцийн зарчимд нийцүүлэн эмэгтэйчүүдэд ээлтэй эрх зүйн орчин бүрдүүлж батлах, хариуцлагыг холбогдох хуульд оновчтой тусгах
- Бага насны хүүхэдтэй ээж, хөдөөгийн болон албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн хэрэгцээнд суурилсан зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин бүрдүүлэх

ХОЁР. Охид, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангах хүрээнд:

- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх, тэр дунд цэцэрлэг, сургуулийн сургалтын агуулгад ялгаварлан гадуурхахгүй байх, хүчирхийлэлгүйгээр асуудлыг шийдвэр зан төлөвт сургах асуудлыг тусган нэвтрүүлэх
- Бага насны хүүхдийг хараа хяналтгүй үлдээхгүй байх эцэг, эхийн үүргийг хариуцлагажуулах, Гэр бүлийн тухай хуулинд тусган, баталгаажуулах
- Хүчирхийлэлд өртөж хохирсон тохиолдолд сэтгэл санааны хохирлыг тооцох, сэтгэл санааны хохирлыг нөхөх үйлчилгээг төрөөс үзүүлэх
- Охид эмэгтэйчүүдийг хүчирхийллээс ангид байлгах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд оновчтой шийдвэрлэх хүрээнд Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шаардлагатай зарим нэмэлт өөрчлөлтийг тусгах

ГУРАВ. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангах хүрээнд:

- Улс төрийн сонгуулийн тогтолцоог эмэгтэйчүүдэд ээлтэй болгох, нэр дэвших шалгуур үзүүлэлтийг мэдлэг, туршлага, чадвараар уралдуулах
- Олон улсын амжилтад хүрсэн сайн туршлага буюу сонгуульд нэр дэвшигчдийн бус суудлын квотын тусгай арга хэмжээ авах
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмийг холбогдох эрх зүйн бичиг баримтуудад суулгах

Охид эмэгтэйчүүдийн тэгш эрхийн төлөө эдгээр саналуудыг хөгжлийн бодлого, төлөвлөгөөндөө шингээх үүрэг хүлээж буй аль ч нам, улс төрийн байгууллагуудыг бид дэмжиж, хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаа илэрхийлж байна.

“ИЛҮҮ САЙХАН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ” ОЛОН УЛСЫН ЧУУЛГА-УУЛЗАЛТАД ОРОЛЦОГЧИД

Улаанбаатар хот. Төрийн ордон. 2019 оны 9 дүгээр сарын 17.



МАН



МАНХН



АН



МЭХ